



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/54

Хөхбүрд

Ажлын байр нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний
хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын байр нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Эрдэнэбулган (Санхүүгийн албаны дарга)

Гишүүд: Г.Ууганжаргал (Бичиг хэргийн ажилтан)

М.Жавзансүрэн (Тамгын газрын дарга)

Ж.Ганцэцэг (Хөндлөнгийн гишүүн)

Нарийн бичгийн дарга: Д.Отгонцэцэг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2. Тендерийн үнэлгээний хороонд ажиллах гишүүд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасан мэдээллийг гаргаж, тендерт сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа авах үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллахыг үнэлгээний хорооны гишүүдэд даалгасугай.

3. Тендерийн материалыг баталгаажуулан стандартын дагуу архивын нэгж үүсгэн Засаг даргын Тамгын газрын архивт хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Отгонцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР



642301097